

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл №1**

Ажлын хэсгийн хуралдаан Монголын Үндэсний Уул уурхайн ассоциацийн хурлын танхимд 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 15 цагт болов.

Хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр, ажлын хэсгийн гишүүд: Монголын үндэсний үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн Н.Дашзэвэг, Миний монголын газар шороо хөдөлгөөний гүйцэтгэх захирал Б.Болдбаатар, БОЯ-ны ХБОБНГ-ын дарга, Ажлын хэсгийн гишүүн Ц.Банзрагч, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Байгаль хамгаалах ТББ-уудын холбооны тэргүүн Ж.Батболд, Ил тод сангийн тэргүүн Ц.Ганболд, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын ерөнхийлөгч Л.Дондог, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Онги голынхон хөдөлгөөний тэргүүн Ц.Мөнхбаяр, Айвенхоу майнз компанийн дэд ерөнхийлөгч А.Мөнхбатыг төлөөлж тус компаний дэд захирал Ц.Содхүү, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга Л.Болдыг төлөөлж тус газрын ахлах мэргэжилтэн Х.Хэрлэн, Улсын мэргэжлийн хяналтын газрын дэд дарга Г.Зянаамядарыг төлөөлж Санхүүгийн хяналтын хэлтсийн дарга н.Цэдэнжав, Сангийн яамны ТБЗГ-ын дарга Б.Батжаргалыг төлөөлж тус газрын мэргэжилтэн М.Оюунзаяа, Монголын алт корпорацийн Ерөнхийлөгч, Ажлын хэсгийн гишүүн Б.Нямтайширыг төлөөлж хэлтсийн дарга н.Энхбаяр, Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгааг төлөөлж УУҮА-ийн ерөнхийлөгч Д.Ганболд нар оролцов. Хуралдааны ирц 69.5 хувь байв.

Хуралдаанд ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Ажлын албаны санхүүгийн ажилтан Т.Хүрэлчимэг, Crane White and Associates компанийн зөвлөх Нил Синклейр /Neil Sinclair/, Crane White and Associates компанийн зөвлөх Филип Жеферсон /Philip Jefferson/, Crane White and Associates компанийн захирал Дисмонд Крейн /Desmond Crane/, Орчуулагч Д.Ганхуяг нар оролцов.

Хуралдааныг Ажлын хэсгийн ахлагч Д.Батбаяр нээж, хэлэлцэх асуудлыг танилцуулав.

**Хуралдаанаар хэлэлцсэн асуудал:**

1. ОУИТБС-ын компанийн болон Засгийн газрын тайланд аудит хийсэн тухай /Австралийн Крейн Уайт энд асоушэтс компанийн захирал Дисмонд Крейн танилцуулна/

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх бэлтгэл хангах, тайлан гаргах ажлын товч тайлан /Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа)

3. 2008 оны ажлын төлөвлөгөөний төсөл /Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулна/

Д.Батбаяр: Хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллын дагуу аудитын дүгнэлтийг эхлээд сонсоцгооё.

Австралийн Крейн Уаит энд ассоушэТС компанийн захирал Дисмонд Крейн аудитын дүнг танилцуулав. /Илтгэлийг хавсаргав./

Д.Батбаяр: Аудитын дүгнэлт дээр асууж тодруулах зүйл байна уу?

Ж.Батболд: За би хэдэн зүйл тодруулмаар байна. Нэгдүгээрт аудиторуудад одоо хэдий хэр хугацаа үлдэв ээ? Засгийн газрын болон компаниудын тайлангийн хооронд 100 тэрбумын зөрөө гарч байгаа гэж ойлголоо. Бидэнд энэ зөрүүг тайлбарлаж өгч чадах уу? Мөн та нар олон улсын аудитын ямар аргачлал, стандартын барьж ажилласан бэ?

Дисмонд Крейн: Бидэнд хугацаа бага үлдсэн. Энэ ажил маань 12-р сарын 17-ноос эхэлж сарын хугацаатай ажиллах төлөвлөгөөтэй. Бид 100 тэрбумын зөрүүг дотор нь задалж ямар шалтгаантай болохыг тогтоохоор ажиллаж байгаа. Түрүүчийн 7 хоногт Үндэсний татварын ерөнхий газраас ирүүлсэн тодруулгад тайлан дээрх тоонууд урьд нь Засгийн газрын тайлан дээр тавигдсан тоонуудаас их зөрүүтэй байгааг би урьд нь хэлсэн.

Энэ зөрүүнүүд эцсийн тайлан дээр тодорхой болох байх. Бид Засгийн газрын гаргасан тайланг компаниудын гаргасантай харьцуулж зөрүүнүүдийг тогтоох, тодруулах чиглэлээр ажилласан. Бидний тодруулгын явцад зарим компаниуд өөрийн компанийн маягтаар гаргасан тайлан үнэн зөв гэж баталсан байхад зарим нь бүр огт шинэ тайланг өнгөрсөн 5 дахь өдөр гаргаж өгсөн нь ч байгаа.

Бид Засгийн газрыг төлөөлж Татварын ерөнхий газартай голлож ажилласан. Татварын ерөнхий газрын гаргасан гаалийн татварын дүнг Гаалийн ерөнхий газар дээр очиж тодруулж баталгаажуулсан. Мэдээлэл боловсруулах явцыг авч үзэхэд Татварын ерөнхий газар нь зөвхөн нэгтгэх, боловсруулах үүрэгтэй байсан нь ажиглагдсан.

Л.Дондог: Танай компани ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ? Компанийн зөвлөхүүд ямар мэргэжилтэй вэ? ОУИТБС-ын тайлангийн тодруулга хийхийн тулд хэдэн компани дээр очиж ажилласан бэ?

Дисмонд Крейн: Голлох үйл ажиллагааг Крейн миний бие болон Уаит гэдэг зөвлөх бид хоёр хариуцаж ажиллаж байгаа. Бид урьд нь олон улсын зөвлөх компанид ажиллаж байгаад бие даасан зөвлөх болон аудитын үйлчилгээ үзүүлдэг компани байгуулсан юм.

Бид хамгийн сүүлд Азийн хөгжлийн банкны нябо бүртгэлийн тогтолцоог шинэчлэх төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Манай Филип Жеферсон урьд нь Австралийн компаниудад энэ чиглэлээр ажиллаж байсан, өөрийн хувийн зөвлөх компанитай. Тэтгэвэртээ гарсны дараа бидэнтэй хамтарч ажиллаж байгаа юм. Нил Синклайрын хувьд Австрали болон АНУ-д зөвлөх үйлчилгээний компаниудад ажиллаж байсан туршлагатай хүн юм аа.

Бид энэ төслийн хүрээнд төрийн байгууллагуудаас Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, компаниудаас Айвенхоу, Бороо гоулд, Дацан трэйд зэрэг компаниуд дээр очиж ажилласан.

Ц.Ганболд: Монголын уул уурхайн томоохон компаниуд болох Айвенхоу 7 тэрбум, Алтандорнод монгол 2 тэрбум, Бороогоулд 6 тэрбум, Монголросцветмет 1 гаруй тэрбум төгрөгөөр тус тус төсөвт өгсөн мөнгөтэйгээ зөрж харагдаж байна.

Энэ зөрүүнүүдийг юунаас болж гарсан гэдгийг тогтоосон уу? Анхан шатны санхүүгийн баримтуудыг шалгасан уу? Хэрэв Эксэлийн програм дээр 2 тооны зөрүүг л гаргаад болох байсан юм бол манай аудитын компаниуд ч хийж чадах л байж шүү дээ.

Дисмонд Крэйн: Хугацааны хувьд давчуу байсан гэдгийг хэлэх хэрэгтэй байх аа. Хугацаа урт байх ёстой, шинэ жилийн баяр, оны эцсийн тайлан гэх мэтээр давхцаж, ажилд хүндрэл учруулсан зүйл байгаа.

Анхан шатны санхүүгийн баримтаа компаниуд гаргаж үзүүлэх нь эргэлзээтэй асуудал. Үүнтэй адил Засгийн газрын байгууллагууд ч баримт үзүүлэх байсан болов уу. Тэр их хэмжээний зөрүү ихэнх нь Засгийн газрын гаргаж өгсөн тайлан дээр байгаа. Тэгэхээр улсын хэмжээнд татварын мэдээлэл бүрдүүлэх бүртгэлийн систем ч үүнд бас хамаатай гэж бодож байна. Өөрөөр хэлбэл харъяа татварын байгууллагууд зөрүүтэй тоо өгөх эсхүл огт мэдээлэхгүй байснаас энэ зөрүү үүссэн байгаа.

Ц.Ганболд: Анхан шатны баримтуудыг ер шалгаагүй, хааяа нэг утсаар ярьчихаад сууж байсан гэж ойлгогдож байна, энэ аудит.

Дисмонд Крэйн: Бид утсаар ч ярьсан, факсаар ч харилцсан, шаардлагатай тохиолдлуудад очиж ч уулзсан. Бид компанийн санхүүд аудит хийх үүрэгтэй биш харин тайлангийн зөрүү юунаас болж гарсныг тогтоох үүрэгтэй юм аа.

Д.Батбаяр: Өөр асуулт байхгүй бол саналаа хэлцгээе.

Ц.Ганболд: Киргизэд 600 мянган ам. доллараар ОУИТБС-н аудит хийлгээд ямар ч үр дүнтэй юм гараагүй байдаг юм. Тэрэн шиг юм болж байгаа юм биш үү. Ер нь 304 мянган ам. доллараар юу хийж байна, тодруулга авъя. Гэрээгээ цуцлахад болохгүй юмгүй.

Ж.Батболд: Энэ их зөрүүнүүд юунаас болж гараад байна. Би Ганболдтой санал нэг байна. Ер нь аудитыг дотоодын компаниар хийлгээд, зөрүү гарвал түүнд олон улсын компани ажиллуулах нь зүйтэй байна. Үндэсний Зөвлөл дээр сайн ярих хэрэгтэй байна.

Н.Дашзэвэг: Би дээрх хоёр хүнтэй санал нэг байна. Заавал гадны компаниудаар аудит хийлгэх шаардлага байна уу? Ажлын алба нь өөрөө хийдэг байвал яаж байна гэсэн санал өгч байна. Энэ аудит бол зорилгоо хангасангүй гэж үзэж байна.

Хандив тусламжийг татварын албаар дамжуулан өгдөг байх саналыг тавьж байна. Бид өөрсдөө энэ бүхнийг хийж сурах хэрэгтэй. Харин чадахгүй юмаа гадны аудитаар хийлгэе.

Л.Дондог: Манайхны буруу байна. Энэ аудит болж чадсангүй ээ. Хугацаагаа ч буруу сонгож. Тэгээд гол нь авилгал илрүүлэх зорилготой ш дээ. Хэн хэнд юу өгч вэ гэдгийг тодруулах хэрэгтэй. Компанийн санхүүг бүхэлд нь шалгахгүй 5, 10 шилжүүлэг л шалгана ш дээ. Нотолгоог нь үзэх хэрэгтэй. Үүнийг цаашдаа анхаарах ёстой.

Бид уул нь тайлангаа гаргах талаар сургалт явуулсан л даа. Хугацааг нь жаахан эртдүүлсэн байх шиг байна. Аудит гэдэг нь бүгдийг нүдээр үзнэ гэсэн олон улсын стандарт шүү дээ.

н.Цэдэнжав: Энэ бол аудитын үйлчилгээ биш зөвлөх үйлчилгээ шинжтэй юм гэж ойлгогдож байна. Цаг хугацаа хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудлууд бий байх. Энэ ажлыг бид /Ажлын хэсэг/ үргэлжлүүлэх хэрэгтэй. ТББ-аар аудит хийлгэх саналтай, үүний тулд тэднийг сургах хэрэгтэй байна.

Д.Ганболд: Би гэрээн дээр нь юу гэж заасныг мэдмээр байна. Зөвлөхийн үйлчилгээ үзүүл гэж гэрээ хийчихээд аудит хийсэнгүй гээд загнаад байх бол утгагүй шүү дээ. Ямар ажил хий гэж гэрээндээ заасан юм бэ? Би бол үүнийг мэдээллийн зөрүү буруу ойлголт гэж бодож байна.

Ш.Цолмон: Гэрээ 11 сард байгуулагдаж, 12 сард ажлаа дуусгахаар төлөвлөгдөж байсан боловч тендер шалгаруулахтай холбоотой ДБ-ны журмын дагуу процедуруудад хугацаа алдаж 12 сард байгуулагдсан. Гэрээний дүн 101 мянган ам.доллар, үүнээс 20 орчим мянга нь татвар байгаа юм. Гэрээн дээр Монгол улсын ОУИТБС-н 2006 оны нэгдсэн тайланг гаргах үүрэгтэй гэж заасан байгаа. Энэ бол сонгодог утгаараа зөвлөхийн үйлчилгээ юм. Гэхдээ шаардлагатай тохиолдолд санхүүгийн анхан шатны баримтыг үзнэ гэж заасан байгаа. Хамгийн гол нь үндэслэлийг нь гаргаж өгөх юм.

Ц.Ганболд: Цолмон чи буруу ярьж байна. Эд нар Монгол улсын тайланг гаргах үүрэгтэй гэдэг чинь юу гэсэн үг юм бэ?

Ш.Цолмон: Би буруу яриагүй. ОУИТБС-н 2006 оны нэгдсэн тайланг гаргахын тулд энэ хүмүүс ажиллаж байгаа.

Д.Батбаяр: Санал хүсэлттэй холбогдуулаад ноён Крэйнд хэлэх зүйлийг нь сонсьё.

Дисмонд Крэй: Би эхэнд хэлсэн. Энэ та бүхэнд танилцуулж байгаа тайлан бол зөвхөн анхны төсөл хэлбэрээрээ тайлан шүү. Өнгөрсөн 5 дахь өдөр Татварын ерөнхий газраас ирүүлсэн тайлангаас болж их зөрүү гарч байгаа. Үүн дээр бид ажиллаж байна. Зөрүүний 60 тэрбум нь оны эцсийн хугацаанаас хамаарсан зөрүү байна гэдгийг тогтоосон.

Д.Батбаяр: Зөвлөхүүдэд баярлалаа. Та бүхэнд ажлаа үргэлжлүүлэхэд цаг хэрэгтэй тул явж болно. (Гадаадын оролцогчид хуралдааны танхимаас гарч явав.)

Дараагийн асуудалдаа оръё. Сумъяа 2007 оны хийсэн ажлын тайлангаа танилцуулна.

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа товч тайланг танилцуулав. (Товч тайлан, төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав)

Ц.Ганболд: Ер нь ингэж өндөр үнэтэй үр дүн муутай аудит гэдэг юм хийх шаардлага байна уу? Үнэлгээний хороонд манай төрийн бус байгууллагын эвслээс хүн орсон муу ажилласан байна. Энэ зөвлөхүүдийн мөнгийг нь өгөхгүй байх хэрэгтэй, санасандаа хүрсэн тайлан автлаа. Ер нь эдний үйл ажиллагааны талаар Дэлхийн банкинд гомдол тавих хэрэгтэй.

Ц.Мөнхбаяр: Дэлхийн банкнаас мөнгө авч байгаа ч гэсэн заавал тэдний заавраар өндөр үнэтэй иймэрхүү зөвлөхүүдийг хөлслөх хэрэг байна уу? Тэр дэлхийд нэртэй Уорлд мониторинг г.м байгууллагуудыг хөлсөлбөл ямар вэ?

Д.Батбаяр: хамгийн гол нь Монгол улсын ОУИТБС-ын тайланг анх удаа гаргах асуудал ш дээ. Хугацаа алдсан тухайд Дэлхийн банкны сонгон шалгаруулалтын журам, мөнгө гаргагчаас шалтгаалсан. Асуудал шийдвэрлэх үе шат бүрт цааш явах арга зам, асуудлаа Дэлхийн банкинд явуулж хариу ирэхийг хүлээдэг ийм л журмаар явдаг юм байна. Аудит хийх гэрээ байгуулагдсан, гэрээний биелэлтээс хамаарч мөнгийг өгнө шүү дээ.

Д.Ганболд: Заавал энэ хэдийг муулахдаа биш шүү дээ. Харин ч бидний судлаж үзэх ёстой асуудлуудыг гаргаж өгч байна. Үүнийг бид өөрсдөө ч бас судалж учрыг нь олох ёстой. Харин ийм зөрүү гарлаа гээд маргааш цагдаа руу бариад гүйж болохгүй л дээ.

Ц.Содхүү: Сая гарсан жишээн дотор манай компани дээр 8, 0 тэрбумын зөрүү байна гээд л яригдсан. Үүнийг аудит хийж байгаа хүмүүс манай компани дээр очиж үзсэн, мөн татварын албаны тодруулгаар он дамжсан шилжүүлэг байна гээд зөрүүний учрыг нь олсон шүү дээ.

Д.Батбаяр: Товч тайлангаа Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулна. Гурав дахь асуудлаа хэлэлцэе. Цолмон 2008 оны төлөвлөгөөгөө танилцуулна.

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон 2008 оны ажлын төлөвлөгөөгөө танилцуулав. (Төлөвлөгөөний төслийг хавсаргав)

Д.Батбаяр: Асуулт, санал байна уу?

Ц.Ганболд: Энэ 2008 оны санхүүжилтээ бүрэн шийдсэн байгаа юу?

Ш.Цолмон: За энэ асуултанд Хүрэлчимэг хариулна.

Т.Хүрэлчимэг: Дэлхийн банк буюу Хандивлагчдын итгэлийн сангаас 304 мянган долларын санхүүжилтийг авахаар гэрээ хийгдсэн байгаа. Энэ гэрээ 2007 оны 12-р сарын 31-нд дуусахаар заагдсан байсныг 2008 оны 12-р сарын 31 хүртэл төслийг хугацааг сунгуулсан байгаа. Энэ хөрөнгийг тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ, сургалт, үйл ажиллагаа гэсэн зөвшөөрөгдсөн зардлын төрлүүдээр

зарцуулах юм. Тухайлбал: 15,1 мянган доллар тоног төхөөрөмж авахад, 168 мянган ам.долларыг зөвлөх үйлчилгээнд, 79,2 мянган ам.долларыг сургалтанд, 41,8 мянган ам.долларыг үйл ажиллагааны зардалд тус тус хуваарилагдсан байгаа.

Одоогоор бид дээрх дөрвөн төрлийн зардалд 32 мянган ам.долларыг зарцуулчихаад байна. Харин энэ аудитын төлбөрт 1 ч ам.долларыг төлөөгүй байгаа бөгөөд хийсэн ажлын гүйцэтгэлээр төлөгдөхөөр гэрээнд заагдсан байгаа тул биднээс хөлсөө нэхэмжлээгүй байгаа.

Д.Ганболд: Би нэг санал хэлье. Энэ гаалиар гарч байгаа ашигт малтмалын судалгаа тоо хэмжээг ил болгох хэрэгтэй байна. Энэ тал дээр Батбаяр зөвлөх та санаа тавьж өгнө үү. Бидний хувьд лиценз эзэмшигчидийн бүртгэлийг сайжруулж, хаяг байршил, үйл ажиллагаагаар нь мэдээллийн сан бүрдүүлэхээр төлөвлөж байна.

Ж.Батболд: Санаачлагын зарчмыг бүгдийг хэрэгжүүлэхээр тусгах, ил тод болгох, хэвлэлийн бага хурал хийх, хүнийг мууг үзэхдээ биш, юу олсныг иргэдэд мэдээлдэг болгох. Аудитын дүнгийн тухай хэвлэлийн бага хурал хийх асуудлыг ажлын төлөвлөгөөнд оруулья

Э.Сумьяа: Энэ ажил тусгагдсан байгаа. Та бүхэн төлөвлөгөөний төсөлтэйгээ танилцаж байж саналаа хэлэл дээ.

Б.Болдбаатар: Гаалиар гарч байгаа ашигт малтмал, хүдэр гаргалт дээр гаалийн байгууллагатай хамтарч ажиллах, ялангуяа ямар сорьцтой хүдэр гаргав, хэдий хэмжээтэй гаргав гэдгийг мэдэж байх зэрэг асуудлыг асуудлыг төлөвлөгөөнд оруулья.

Ц.Ганболд: Төлөвлөгөөн дээр Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас мөнгө гаргах, Үндэсний зөвлөлд хүн нэмэх асуудал боловсруулахад мөнгө гаргах, урилга гаргах гээд утгагүй асуудлууд байна. Мөн төрийн бус байгууллагын нэр нэг ч алга, бид тэр зардлаар чинь ажилламаар байна. Орон нутгийн хандивын тайлан гарч чадаагүй байна, түүнийг оруулах, мөнгөний тэмдэг буруу байгааг анхаарах. 2006 оны үр дүнгийн асуудлыг одоо ярих нь уул нь их утгагүй байна. Гэхдээ яахав. Төсвийн зарцуулалтыг ил тод болгох асуудлыг төлөвлөгөөнд оруулах хэрэгтэй байна. Уул уурхайг бүхэлд нь ил тод болгох ажлыг тусгах, бид ч тэгж ажиллана. Тусгай зөвшөөрлийн төлбөр, нөөц ашигласны төлбөрийн зарим хэсэг аймаг, сумын төсөвт очих ёстой, гэтэл очихгүй байна. Сүхбаатар аймаг том уурхай ашиглахаас өмнө 2 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан, уурхайгаас нь их орлого улсад орж байхад одоо ч 2 тэрбум төгрөгийн төсөвтэй хэвээр байна. Хууль хэрэгжихгүй байна. Үүнийг Батбаяр зөвлөх Ерөнхий сайд С.Баярт танилцуулах. Засгийн газар зардал гаргахгүй байна, бид өнөөдөр Уул уурхайн ассоциацийн байранд хуралдаж байна. Энэ Засгийн газрын мөнгөөр хийгээгүй. Засгийн газар зарим зардлыг улсын төсөвт тусгаж гаргах хэрэгтэй. Гадаадад явж туршлага судалж яах юм бэ, харин дотооддоо явж ажиллах хэрэгтэй байна.

Э.Сумьяа: Засгийн газраас гаргах санхүүжилтийг хэрхэн тооцох талаар Дэлхийн банктай тохирсон, тэр дагуу л төсвийнхөн өөрсдийн хийсэн ажлын зардлаа оруулахаар тооцсон. 1 хуудас материал боловсруулахад ч ямар нэг хүний хөдөлмөр шингэж, зардал гардаг гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Тэр тусламжийн

мөнгөнөөс төсвийнхөнд 1 цент ирэхгүй, бүгд хандивлагчтай тохирсон зүйлдээ зарцуулна. Тусламжийн мөнгийг авлаа гээд бид зарцуулалтыг мэднэ гэж ойлгож болохгүй. Уриалга шаардлагатай үедээ эзнээ олбол хэрэгтэй л байдаг юм билээ. Улсын төсөвт зардал тусгах гээд төлөвлөгөөний төсөлд оруулсан.

Н.Дорждарь: 2007 оны үр дүнгийн аудитыг наадмаас өмнө хийх хэрэгтэй байна. Дэлхийн банк нэг их цааргалахгүй байх.

Н.Дашзэвэг: Ер нь ТББ-уудаар аудит хийлгэх хэрэгтэй байна. Бид бага зардлаар иймэрхүү аудит хийчихнэ, цаана бас бид чадавжина, 1 ч гэсэн компьютертэй болно.

Ц.Мөнхбаяр: Ил тод байдлын хуулийг гаргах, эрхзүйн хувьд тодорхой болгох хэрэгтэй байна. Мөн санал асуулга гэж төлөвлөгөөнд байна, үүнийг ажлын хэсэг хөдөө явж хийх, хуулинд орон нутагт дэмжлэг үзүүлэх гэсэн хууль ёсны авилгалын заалт бий, үүнийг болиулж улс зөвхөн татвар авч, түүнээ орон нутагт өгч дэмжлэг болгох хэрэгтэй.

Д.Ганболд: Идэвхтэй үйл ажиллагаа л аж ахуйг тодорхойлно. Аль нь ажиллаж байгаа, аль нь ажиллахгүй байгааг тогтоож өгөх нь зөв.

н.Энхбаяр: Би МАК-аас ерөнхийлөгчийнхөө оронд ирсэн. Манай ерөнхийлөгч өөрөө оролцох гэж байсан боловч гэнэтийн ажил гараад ирж чадсангүй ээ. Надаар 4 санал явууллаа. Үүнийг уншаад өгчихье. 1/ Нүүрс устөрөгч болон уул уурхайн бүтээгдэхүүний сүүлийн 3 жилийн экспортын хэмжээг гаргах, мөн тэр хугацаанд төлсөн татвар хураамжийн хэмжээг аж ахуйн нэгж бүрээр гаргах, том уурхайг тусад нь мэдээлэх 2/ олборлох салбараас улсын төсөвт оруулсан орлогын зориулалт, зарцуулалтаар иргэдэд өгөх мэдээллийн төсөл боловсруулах, иргэдэд мэдээлэх, аргачлал боловсруулах, 3/олборлох салбарын аж ахуйн нэгж бүрээр орлого, ашиг, татвар төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, 4/Гадаад дотоодын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, энэ нь ил тод байдлыг хангах нэг нөхцөл, иймд энэ чиглэлээр ажлын хэсэг Тавантолгой, Оюутолгой зэрэг том ордод хөрөнгө оруулах сайн орчны талаар саналаа Засгийн газар, Улсын Их Хуралд өгөх зэрэг болно. (Б.Нямтайширын ирүүлсэн саналыг хавсаргав)

Б.Болдбаатар: Ашигт малтмалыг гадагш гаргах, гаднаас оруулах үйл явц, түүний мэдээ мэдээллийг ил тод болгох асуудлыг оруулахыг дахин хэлэе.

Д.Батбаяр: Ажлын хэсгийн гишүүдийн саналыг тусгаж төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийж Үндэсний зөвлөлөөр батлуулах асуудлыг Э.Сумъяа, Ш.Цолмон 2-т хариуцуулъя.

Э.Сумъяа: Зарим боломжтой саналыг оруулнаа, заримыг нь оруулах боломжгүй гэж бодож байна. Ерөнхий чиг баримжаагаа барихгүй бол ОУИТБС-ын зарчим болон утга санаагаа алдана. Хөрөнгө оруулалтын тухайд Хөгжлийн зөвлөл байгуулагдан ажиллаж байгаа бол, хил гааль, мэргэжлийн байгууллагын хийх ажлын талаар санал олон гарсныг тусгамааргүй байна.

Хуралдааны явц, үр дүнгийн талаар Өглөөний сонины сурвалжлагч, SBN Телевизийн оператор оролцож сурвалжлага бэлтгэв.

Ажлын хэсгийн хуралдаан 18 цаг 30 минутад дуусав.

Хуралдааны тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч



Д.Батбаяр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОУИТБС-ын Ажлын албаны ажилтан



Т.Хүрэлчимэг